



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/610

Есонбулаг

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тогтоолоор баталсан "Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 7.1, 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан иргэн, Аж ахуйн нэгжүүдийн төслийн хэрэгжилтийн явц, зээлийн эргэн төлөлтөд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд илэрсэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Хаш-Эрдэнэ	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:	Х.Баатарзориг	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
	Э.Пүрэвжав	(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Х.Лхагважав	(Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Р.Цэнд-Аюуш	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

2. Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, журмын хүрээнд холбогдох арга хэмжээ авч ажиллаж, үр дүнг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ